

Амьс дугаар ТАВАН ЖИЛ

ТӨВ АЙМГИЙН НАМЫН ХОРОО,
АДХ ГҮЙЦЭГТЭХ ЗАХИРГААНЫ СОНИН.

13-дэх жилдээ
№52 (10100)

1961 оны
7 дугаар сарын 3

ДАВАА

МАХН-ын 14 дүгээр их хурал

Манай намын ээлжит 14 дүгээр их хурал өнөөдөр Улаанбаатар хотноо нээгдэв.

Тус их хурал: МАХН-ын Төв Хорооны тайлан илтгэл, Шалган байцаах комиссын тайлан илтгэл, 3 дугаар таван жилийн төлөвлөгөөний талаар намаас их удирдамж, намын төв байгууллагуудыг сонгох зэрэг асуудлуудыг хэлэлцэж байна.

МАХН-ын 14 дүгээр их хурлын аугаа их ач холбогдол нь; юуны өмнө манай нийгмийн хөгжилтөд шинэ үе социализмын өрнүүлэн байгуулалтын материал техникийн бааз байгуулах асуудлыг шийдвэрлэхэд оршино.

Намын 13 дугаар их хурлаас хойш манай орны улс төр, эдийн засаг, соёлын амьдрал асар их өөрчлөлтүүд гарлаа.

МАХН-ын Төв Хорооны 3, 4 дүгээр бүгд хурлын түүхт шийдвэрт зоригжсон тус аймгийн хөдөлмөрчид хөдөө аж ахуйг хоршоолдох ажлыг амжилттай дуусгав.

Үүний үрээр аж ахуй соёлын бүх салбарт үерхгүй амжилтууд өдөр цаг минут дутамд гарч байна.

Манай аймаг 1961 онд хөдөө аж ахуйн нэгдэл 21-тэй болж үүний 77 хувь нь цахилгаан, 61 хувь нь утсан харилцаа, 57 хувь нь радио үз лтэй болсны дээр аж ахуй, зохион байгуулалтын хувьд бэхжиж нэгдлийн мөнгөн орлого 25,2 сая төгрөгт хүрч, саяас дээш орлоготой нэгдэл бүх нэгдлийн 40,9 хувийг эзлэх болов.

Улс ардын аж ахуй соёлыг 1961-65 онд хөгжүүлэх 3 дугаар таван жилийн төлөвлөгөөний эхний жилийн тэргүүн хагаст гүйцэтгэх зорилтыг биелүүлэхэд тус аймгийн хамт олон идэвхтэйгээр хөдөлмөрч байна.

Тус сонсны өнөөдрийн дугаарт аймгийн аж ахуй, соёлыг хөгжүүлэх 1961 оны эхний хагас жилийн төлөвлөгөөт ажлын дүнгийн талаар аймгийн тоо бүртгэлийн товчооны мэдээ нийтлэгдэв.

Үүнээс үзвэл төрөл бүрийн малын төл бийжилт 95,4 хувь, хаврын тариа ногоо тариалалт 107,9 хувь, мал бэлтгэл 100,1 хувь, бодын хөөвөр хялгас 109,1-104,4 хувь, ба-

гаа гүйлгээ 103,3 хувиар биелэгдээд байна.

Үйлдвэр, үйлдвэрлэлийн хоршооллол, тээвэр, харилцаа холбооны байгууллагууд төлөвлөгөөгөө 6,1-35 хувиар давуулан биелүүлж, ард түмний аж амьдрал соёлын хэмжээг дээшлүүлэхэд их амжилтанд хүрсэн сайхан дүнгээр манай аймгийн бүтээлч хөдөлмөрчид намынхаа их хурлыг угтлаа.

Монголын ард түмний ирээдүйг гэрэлтүүлэгч ол, МАХН-ын алдарт 14 дүгээр их хурлын түүхт шийдвэр, 3 дугаар таван жилийн төлөвлөгөөг амьдралд хэрэгжүүлэн биелүүлэхэд тус аймгийн намын байгууллагууд, хамт олон зориг төгөлдөр байгаагаа их хурлын өдрүүдэд илэрхийлсээр байна.

Энэ бол социализмын гэргэн саруул замыг зааж өгсөн намынхаа 14 дүгээр их хурлын шийдвэрийг амжилттай биелүүлэх тод илрэл мөн.

Намын их хурал нь өөрийн орны хөгжилтийг дүгнэхийн хамт, манай урагшлах хөдөлгөөнд саад тотгор болсон хуучирч үзэ өнгөрүүлсэн бүхнийг эрс шийдвэртэй тайлан хаяж

ирээдүйн шинэ замыг зааж өгнө.

Ийм чадалтай марксист-ленинст нам социалист хөгжлийн бүх явцыг удирдаж байгаа болохоор манай хөдөлмөрчид намынхаа шийдвэрт улам зоригжиж байдаг юм.

Манай орны социализмын өрнүүлэн байгуулалтын аугаа их төлөвлөгөөт зорилтыг амьдралд амжилттай хэрэгжүүлэн биелүүлэхийн төлөө ард түмний тэмцлийг МАХН, төрийн удирдах хүчний хувьд манлайлах үүрэгтэй юм.

Ийм учраас олон түмний дотор зохион явуулах улс төр, олон түмний ба үзэл суртал зохион байгуулалтын ажлыг улам эрч далайцтай болгож олон түмний ухамсартай хөдөлгөөнийг өрнүүлж 14 дүгээр их хурлын шийдвэрийг амжилттай биелүүлэхэд нам улс олон нийтийн бүх байгууллага ажлаа чиглүүлэх ёстой.

Манай аймгийн хөдөлмөрт дуртай ард түмэн алдарт намынхаа 14 дүгээр их хурлын дайчин шийдвэрийг баяртай хүлээн авч хэрэгжүүлэн биелүүлэхэд итгэл төгс байна.



ЗУРАГ
ДЭЭР:
Баян Сумын бага сургуулийн эрхлэгч Гүнсэноров сүүлийн 3 жил дараалан өөрийнхөө хариуцсан аргийг 100 хувийн дүйтэй сургажээ.

Гүнсэноров бүтээлч амьдралаараа шалгарч багш нарын их хуралд төлөөлөгчөөр сонгогджээ.

(Д. Дондогдоржийн зураг)

Аймгийн аж ахуй соёлыг хөгжүүлэх 1961 оны эхний хагас жилийн төлөвлөгөөт ажлын дүн

Тус аймгийн хөдөлмөрчид МАХН-ын 14 дүгээр их хурал, ардын хувьсгалын 40 жилийн ойг угтаж 1961 оны эхний хагас жилийн аж ахуй, соёлын төлөвлөгөөг хугацааны нь өмнө давуулан биелүүлэхийн төлөө социалист уралдааныг өрнүүлэн ажиллаад их амжилт оллоо.

Аймгийн 1961 оны эхний хагас жилийн төлөвлөгөөт ажлын явцыг улс ардын аж ахуйн салбаруудаар үзүүлбэл:

НЭГ. Хөдөө аж ахуйн талаар

Гарсан төлөө 95,4 хувиар бойжуулж малын хорогдлыг багасгаснаар 1961 онд мал өсгөх улсын төлөвлөгөөг давуулж Булган аймгийн хө-

дөлмөрчидтэй байгуулсан уралдаанд амласан мал өсгөх зорилтоо биелүүлэх боломжийг оллоо.

Аймгийн хэмжээгээр хаврын тариалангийн төлөвлөгөөг 107,9 хувиар биелүүлж өнгөрсөн снхсоос 55,6 хувиар нэмэгдсэний дотор үр тариа 56 хувь, хүнсний ногоо 64,3 хувь, малын тэжээл 65,2 хувиар өсөв.

Тариалангийн төлөвлөгөөг сангийн аж ахуйнууд 106,4 хувь, ХАА нэгдлүүд 114,4 хувиар биелүүллээ.

Мал аж ахуйн туслах арга хэмжээний гүйцэтгэл 1960 оны эхний хагас жилээс 13-78 хувиар нэмэгдэв.

(Үргэлжлэл нь 2-р нүүрт)

Баяндэлгэр сумын хамт олноос 1961 онд социалист уралдаанд авсан үүрэг

1. 100 эх мал дутмаас ботго 47, унага 70, тугал 85, хурга 90, шинг 90-ийг бойжуулан авч сумын бүх малаа 1,7 хувиар өсгөж, 47488 толгой болгоно.

2. Үүний дотор хээлтэгч малаа 2,5 хувиар өсгөж 20713 толгойд хүргэнэ.

3. Сүүний 170, гүү 1497, үнээ 2333, эм хонь 12597, эм ямаа 4027 толгой болж нэгдлийн нийгмийн малыг 12,3 хувиар өсгөнө. Бух 50, хуц 273, ухна 89 нэмэн тавина.

4. Үүрээ сүүний, хонио нарийн ноосны чиглэлээр өсгөх зорилгоор Сүхев үүдрийн бухаар 400 үнээнд, Алтайн нарийн ноост хуцаар 3500 хонинд зохиомол хээлтүүг хийнэ.

5. Саалийн үнээ дутмаас 500 л. ингэнээс 150 л. гүүнээс 200 л. хониноос 15 л. ямаанаас 20 л. сүү ашиглаж хонь бүрээс уртын ноос 1,3 кг. ахар 400 г. тэмээ бүрээс 5,5 кг. ноос, бод бүрээс 350 г. хөөвөр, адву бүрээс дэл 400 г. сүүд 100 г. ямаа бүрээс ноос 230 г. ноолуур 270 г. ашиглахын хамт ямааны ноолуурын 80 хувийг 5 дугаар сарын нэгний дотор тушаана.

6. Хадлангийн төлөвлөгөөг 102 хувиар биелүүлнэ.

7. Улаан буудай 290 га-д тарьж га дутмаас 10 цовьёос 330 га-д тарьж га дутмаас 10 тонн ургац авна.

8. Малын зүй бусын хорогдлыг өнгөрсөн жилийнхээс 42 хувиар багасгана. Үүний тул тариалгыг 105 хувиар биелүүлж, бүх малдаа улиралд нэг удаа үзлэг хийж эрүүд сүрэгтэн

болох хөдөлгөөнийг өрнүүлнэ.

9. Уурхайн худаг 3-ыг гаргаж, үхрийн хашаа 12, тугалын пүвэ 25-ыг 4 дүгээр сард барьж, үхэр хонь, ямааг хашаа жуулах, чоно 45-ыг 5 дугаар сарын 15-ны дотор устгана.

10. Нэгдлээ суурьшуулж бэхжүүлэх зорилгоор 1961 онд нэгдлийн төвд гуанз зочид буудал, халуун ус, орон сууц, төрөлжсөн агуулах, цахилгаан моторын барилга, машинны гарааж 2,3 дугаар бригадалд халуун ус, улаан булан, бүх бригадаа агуулах, 2 айлын орон сууц тус бүр 2-ыг барьж ардын хувьсгалын 40 жилийн ойн өмнө ашиглаатанд оруулна.

11. Малыг 101 хувь, сүүг 10 дугаар сарын 15 ны дотор 100 хувь, төрөл бүрийн ноосыг хугацаанд нь 100-102 хувиар биелүүлнэ.

12. Бэлтгэсэн бүх тарваганы арсны 75 хувь, цонгийн тосны 90 хувь, түүхий эдийн 80 хувийг 1 дүгээр зэрэгт тушаах тэмцэл тавьж ажиллана.

13. Гиншүүн бүр хөдөлмөргүй байхыг цээрлэж нэг гиншүүн жилдээ 200 хөдөлмөр өдөр бүтэнэ.

14. Нэг хөдөлмөр өдөрт мах 300 г. ногоо 100 г. 4 төгрөг 56 мөнгө олгоно.

15. Сургуулийн 1961-62 оны элсэлтийг 100 хувь, 4 дүгээр ангийн төгсөлтийг 100 хувь хангана.

16. Хүн эмнэлгийн амбулаторийн үзлэг 102 хувиар, орхоногийн ашиглаалтыг 105 хувь, урьдчилан сэргийлэх тариалгыг 106 хувиар биелүүлнэ.

Сум-нэгдлийн дарга

Намын үүрийн дарга

Эвлэлийн үүрийн дарга

БАЯРХҮҮ

СОДНОМ

ДАВААДОРЖ

Аймгийн аж ахуй соёлыг хөгжүүлэх 1961 оны эхний хагас жилийн төлөвлөгөөт ажлын дүн

(Үргэлжлэл)

Төл боджиглын байдлаа ба хаврын төрөлөө, мал аж ахуйн туслах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт-хувиар (сумдаар)

Эзлэх суурь	Сумын нэр	Малын төл бод-жилт	харим тариалан	үхрийн зохиомол хээлтүүлэг	хуудал гаргалт	малын хашаа	чоно устгалт
1.	Баянцагаан	99,2	20,4	—	60	15,9	9
2.	Баян	99,1	72 д	0	10	18,5	50
3.	Заамар	99,1	5,3 д	7,7	33	24,1	58,9
4.	Дэлгэрхаан	99,1	114,8	0	85	107,1	100
5.	Баянбараат	98,8	40	—	83,3	12,8	72,6
6.	Жаргалант	98,5	104,7	39,3	—	—	47
7.	Өнжүүл	98,3	114	—	100	88,2	30,4
8.	Угтаалцайдм	98,3	10,7 д	33,3	—	35,5	39,2
9.	Сэргэлэн	97,9	140	31,5	25	45	37,7
10.	Бүрэн	97,6	132,4	—	80	84,9	100
11.	Баянзүрх	97,2	11,8 д	100	—	17,3	113,1
12.	Баянцогт	97,1	103,1	15,2	20	63,8	22,2
13.	Батсүмбэр	96,9	157	11,6	25	23,5	125
14.	Борнуур	96,1	96,4	0	—	—	26,4
15.	Эрдэнэсант	95,4	81,8	0	—	48,1	209,3
16.	Баяндэлгэр	95,2	99,5	0	0	14,2	57,7
17.	Өндөрширээт	93,1	100,4	0	25	10,7	281,8
18.	Мөнгөнморьт	92,7	100	0	—	107,1	86,6
19.	Тариат	92,6	33,6 д	—	—	7,3	91,1
20.	Алтанбулаг	92,2	109,1	40	100	38,3	101
21.	Эрдэнэ	92,1	89,3	0	33	35,7	84,4
22.	Лүн	91,1	100,2	0	—	11,9	55,6
23.	Баянчандмань	91,1	93	40,6	—	52,5	75,5
24.	Баянжаргалан	90,4	82,1	—	0	6,7	65,2
25.	Архуст	88,2	101,6	25,6	0	—	60,0
26.	ДҮН	95,4	107,9	19,3	41,5	26,3	75,7

Дээрх дүнгээс зүвэл 1961 оныг мал өсгөх эргэлтийн он болгохоор аймгийн нямна 10 дугаар бага хурлаас тавьсан зорилтыг хангалтгүй биелүүлж нилээд сумд төлийн ба малын зүй бусын хорогдлыг багасгах талаар тодорхой арга хэмжээ авч чадаагүй байна.

Баянчандмань, Борнуур, Батсүмбэр зэрэг сумд мал өсгөх 1961 оны төлөвлөгөөг 4-31 хувиар таслах байдалтай байна.

Нийт сумд малын зүй бусын хорогдол, төрөл бүрийн зарлагыг нарийн тооцоож уралдаанд авсан үүргээ биелүүлэх талаар тодорхой ажиллах хэрэгтэй.

Зохиомлоор үнээ хээлтүүлэх төлөвлөгөөг биелүүлэх ажлыг эхлээгүй шахам ба тун хангалтгүй ажиллаж байгаад арга хэмжээ авах нь чухал юм.

Аймгийн чуулганаас баталсан график ёсоор хашаа барих, худал гаргах төлөвлөгөөг биелүүлэх талаар олгогтой ажиллаагүйгээс олонхи сумууд мал аж ахуйн туслах арга хэмжээний төлөвлөгөөгөө тасалдуулжээ.

ХОЁР. Аж үйлдвэр

Аймгийн Анхдугаар таван жил сонин газар хөдөлгөөнтэй төлөвлөгөөг 74,1 мянган хөдөлгөөний дараалт хуудас буюу 19,6 хувиар давуулан биелүүлж, 1960 оны эхний хагас жилээс бүтээгдэхүүний гаргалтыг 26 хувиар нэмэгдүүлжээ.

Үйлдвэрлэлийн хоршооллын холбоо төлөвлөгөөгөө 91,6 мянган төгрөг буюу 6,1 хувиар давуулан биелүүлж 1960 оны эхний хагас жилээс бүтээгдэхүүний гаргалт 14,3 хувиар нэмэгджээ.

Хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийг хувиар үзүүрсн нь: (Сумдаар)

№	Сумын нэр	Сүү	цөцгийн тос	УХ ар-тель	ХБ ангийн талх
1.	Жаргалант	50,7	—	—	—
2.	Борнуур	35,3	—	—	—
3.	Бүрэн	28,8	25,3	—	—
4.	Заамар	26,8	23,1	—	—
5.	Өндөрширээт	25,4	24,9	—	—
6.	Батсүмбэр	25,2	—	—	—
7.	Эрдэнэсант	23,0	22,0	—	—
8.	Өнжүүл	16,0	15,2	—	—
9.	Мөнгөнморьт	15,5	15,0	110,8	—
10.	Дэлгэрхаан	15,4	14,0	—	—
11.	Баянбараат	15,0	14,5	—	—
12.	Баян	13,0	9,2	—	—
13.	Тариат	10,3	—	—	—
14.	Баянцогт	10,3	—	—	—
15.	Баянцагаан	10,0	7,0	—	—
16.	Лүн	9,8	—	104,4	75,3
17.	Баянчандмань	9,8	—	115,6	61,0
18.	Угтаалцайдм	9,7	—	—	—
19.	Сэргэлэн	8,8	9,3	—	—
20.	Баянжаргалан	7,4	6,5	—	—
21.	Алтанбулаг	7,0	—	—	—
22.	Баяндэлгэр	6,9	5,0	—	—
23.	Баянзүрх	5,4	—	—	—
24.	Эрдэнэ	5,1	—	—	—
Аймгийн дүн	16,8	16,6	106,1	71,0	—

Аймгийн хэмжээгээр аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний төлөвлөгөөг 0,2 хувиар тасалж 1960 оны эхний хагас жилээс бүтээгдэхүүний гаргалт 0,5 хувиар дутуу байна.

Аймгийн хүнсний комбинат үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 10,3 хувиар тасалдуулж бүтээгдэхүүний гаргалтыг 1960 оны эхний хагас жи-

лээс 23,4 хувиар багасгажээ.

Цөцгийн тос үйлдвэрлэх төлөвлөгөөг 48,9 хувиар тасалж ааруу, эдэмээр, хуурай сүү зэрэг сүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 74-95 хувиар тасалдуулсан байна.

Сүү бэлтгэх тос үйлдвэрлэх талаар хоцрогдож яваа Архуст, Эрдэнэ, Баянзүрх, Баяндэлгэр, Алтанбулаг, Баянжаргалан сумд мөн 1 кг тосонд зарцуулах сүүг хөдүүлэх замаар цөцгийн тос үйлдвэрлэхэд алагдахад гаргаж байгаа Баянцагаан, Баян, Заамар сумдын нам, улсын удирдлага малын ашиг шимийг хугацаанд нь ашиглан сүү тосны технологийн шаардлагыг хангаж цөцгийн тос үйлдвэрлэх талаар онцгой анхаарах хэрэгтэй.

Нам, улсын өмнө амласан амалт, Булган аймгийн хөдөлмөрчлөлтэй байгуулсан уралдаанд авсан үүргээ биелүүлж хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, сүү ашиг-лалтыг сайжруулан цөцгийн тос үйлдвэрлэх төлөвлөгөөг биелүүлэх талаар шийдвэртэй арга хэмжээ авах явдал аймгийн хүнсний комбинатын хойшлуулаггүй үүрэг болж байна.

ГУРАВ. Тээвэр холбоо, хот нийгмийн хангамж

Авто тээврийн бааз ачаа тээвэрлэлийн төлөвлөгөөг 136,8 т. км буюу 10,9 хувиар давуулан биелүүлж 1960 оны эхний хагас жилээс ачаа тээвэрлэлтийг 25,9 хувиар нэмэгдүүлжээ.

Зорчигдог үйлчлэх ажлыг улам сайжруулж хүн км-ийн төлөвлөгөөг 222,4 мян, хүн км буюу 17 хувиар давуулж 1960 оны эхний хагас жилээс 22,1 хувиар нэмэгдүүлжээ.

Аймгийн харилцаа холбоо телефон станц, салбар радио зангилаа зэрэг харилцаа ашиг-лалтын төлөвлөгөөг 100-135 хувиар биелүүлж 1960 оны эхний хагас жилээс 5-250 хувиар нэмэгдүүлсэн байна.

Аймгийн төвийн үйлчилгээний тасаг хөдөлмөрчлөд боловсроор үйлчилж, үйлчлэх төлөвлөгөөгөө 100-136 хувиар биелүүлж 1960 оны эхний хагас жилээс үйлчлэх ажлын хэмжээ нь 27-110 хувиар өсчээ.

Аймгийн төвийн сууршил, тохиожит, хүн амын өсөлт, соёл боловсон байдалын хэмжээ нь хөдөлмөрчлөд ба албан байгууллагын хэрэг-цээг цахилгаан энергээр бүрэн хангахад авто-базад, бүх харилцааг хөнгөн шуурхай болгож лангуула радио сонголт орчин үеийн техни-кийн хөгжлийн шаардлагат тохируулан эрс сайжруулахыг харилцаа холбоонд шаардаж байна.

ДӨРӨВ. Худалдаа бэлтгэл

Хөдөлмөрчлөд бодит орлого улам дээшилс-ний дүнд аймгийн хэмжээгээр жижиглэн худ-далдаах бараа гүйцэтгэлийн төлөвлөгөөг 762,9 мянган төгрөг буюу 3,9 хувиар давуулан биел-үүлж өнгөрсөн оны мөн үеийнхээс 19,8 хувиар нэмэгджээ.

Худалдаа бэлтгэлийг удирдах газар бараа гүйцэтгэлийн төлөвлөгөөг 597,2 мянган төгрөг буюу 3,3 хувиар давуулж өнгөрсөн оны мөн үеэс 20,5 хувиар өсчээ.



Нийтийн хоол, номын гүйцэтгэл 100-107 хувиар биелүүлжээ.

Эмийн сан, бараа худалдаах төлөвлөгөөг 92,5 мянган төгрөг буюу 33,5 хувиар давуулан биелүүлж 1960 оны эхний хагас жилийнхээс 23,5 хувиар өсөн.

Мал бэлтгэлийн төлөвлөгөөг 100,1 хувиар биелүүлж эхний хагас жилд бэлтгэгдэх хөдлүү-гүүхий эд, ангийн үсний 38 нэр төрлийн төлө-лөгөөт зүйлээс 25-иаг 100-аас дээш хувиар биел-үүлжээ.

(Төгсгөл нь 3 дугаар нүрт)

1965 онд цахилгааны хүч 4,6 дахин, цахилгаан гаргалт 3,6 дахин нэмэг-джээ.



Ойгоо ингэж утгав

Аймгийн УХ Холбооныхон 1961 оны эхний хагас жилийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 6 дугаар сарын 25-нд 103%-иар биелүүлжээ.

Лүн, Мөнгөнморьт, Төв, Баянчандмань артелиуд 1-2 дугаар улирлынхаа төлөвлөгөөг 101,6-119,2 хувиар биелүүлж хөдөлмөрийн бүтээлийг 4,4-13,3 хувиар дээшлүүлж, эдийн өөрийн өртгийг 1,7-13,9 хувиар хямдруулж 1400-40100 төгрөгийн ариалан хэмнэлттэй ажилласан байна.

Лүнгийн артелийн ажилчин Далай, Пагам Мөнгөнморьтын артелийн ажилчин Цэрэнпунцаг, Гомбо, төвийн артелийн ажилчин Должинсүрэн, Дуламсүрэн, Чоймбол, Юу Шу Лай, Лувсанжамц, Баянчандмань артелийн Дансран, Жадамбаа нарын хэдэн арван тэргүүний хүмүүс сар улирал, хагас жилийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 120-200 гаруй хувиар биелүүлж сайхан амжилтыг гаргасан байна.

СХТ бригадууд олноор байгуулагдаж ажиллаж үйлдвэрийн төлөвлөгөөг амжилттай биелүүлж байна.

Үүний дотроос Тавхай ахлагчтай СХ бригад 128%-иар, Дамбий, Нанзад ахлагчтай СХТ бригадууд төлөвлөгөөг 122,4-134,6 %-иар биелүүлжээ.

СХТ бригадын гишүүн Цэрэндах, Лхамжав, Дашцэрэн, Санжид, Цэрэнхорлоо, Должинсүрэн, Дуламсүрэн, Чоймбол, Жамьян-осор, Рагчаа, Цэрэндэжид Санжаа нарын тэргүүний хүмүүс эхний хагас жилийн төлөвлөгөөг 131-199 %-иар биелүүлж бусад ажилчдыг үлдгэрлэн ажиллав.

Тус холбооныхон 30 жилийнхээ ойг утгаж үйлдвэрт шинэ санаачлага тэргүүний туршлагыг нэвтрүүлэх тусгай төлөвлөгөөтэй ажилласны дүнд төвийн артель Улаанбаатар хотын урчуудын артелийн туршлагаар зуухны ховил гарадаг Ишламбатав гэж ажиллуулснаар хөдөлмөрийн бүтээлийг 5,5 дахин нэмэгдүүлэв.

Төвийн артелийн Балжаагийн санаачлагаар усны лаазыг дөрвөлжин хийж байсныг өөрчлөж бөөрөнхий хийдэг болсноор хөдөлмөрийн бүтээлийг 01 хувиар дээшлүүлэн өөрийн өртгийг 0,05 хувиар хямдруулж 1 лаазнаас 500 гр. төмөр хэмнэж бүгд 142 төгрөгийн хэмнэлт гаргажээ.

Оёдолын машины механик Жамьяндоржийн санаачлагаар оёдолын машины дардаг ул төмөр хийж, ажиллагаагүй 2 машиныг ашигласнаар хөдөлмөрийн бүтээлийг 1 хувиар нэмэгдүүлж 396 төгрөгийн ариалан хэмнэлт гаргасан байна.

Тавхай ахлагчтай СХ бригадын хамт олон шивэр ямбуу, төмөр, хөх шир зэргийг хэмнэлттэй зарцуулах, хуучин хаягдал савчин гутлын түрүүг улааж худалдсан зэргээс 1954 төгрөг, мөн Дамбий, Нанзад ахлагчтай бригадууд нь үйлдвэрийн материалыг хэмнэлттэй зарцуулан эсгүүрийн арга ажиллагааг сайжруулан хаягдал даавуу, шивредийн өөдсийг ашиглан хоолны цумх, хүүхдийн парчид, дэрний сав, нарын малгай зэрэг 20 гаруй нэр төрлийн 118 ширхэг үйлдэхүүнийг хийж нийтийн хэрэгцээнд гаргажээ. Дондонжав.

Цахилгаан мэдээний 7 хоног

МАХ Намын 14 дүгээр их хурал, ардын хувьсгалын 40 жилийн ойг утгаж холбоонд соёл боловсон байдлыг нэвтрүүлэх зорилгоор МХЗ Эвлэлийн Төв Хороо, Тээвэр Холбооны Яамнаас орон даяар захидал бичлэгийн 10 хоногийн ажлыг зохион явуулсан билээ.

Энэ нь тус аймгийн олон мянган залуучууд хөдөлмөрдийн урам зоригийг улам бадрааж ялангуяа залуучуудын нөхөрсөг хамтын ажиллагааг өргөжүүлэн батжуулж ажлынхаа арга барил, шинэ санаачлага, тэргүүний туршлагыг харилцан солилцох явдалд чухал ач холбогдолтой болж өнгөрөв.

Энэ ажилд тус аймгийн Жаргалант, Борнуур, Батсүмбэр, Өндөрширээт зэрэг олонх сумдын залуучууд идэвхтэй оролцож 20 гаруй мянган захидал бичсэн байна. Захидлын 10 хоногийн ажлыг амжилттай явуулсны дүгнэж тус аймгийн залуучуудын эвлэлийн байгууллагыг Эвлэлийн Төв Хорооны баярын бичиг, харилцаа холбоог Тээвэр Холбооны Яамны хүндэт үнэмлэх хээр сайшаан шагнасан юм.

Энэ оны 1 дүгээр улиралд Архангай аймгийн төвд болсон тус улсын баруун 10 аймаг, Улаанбаатар хотын тэргүүний холбоочдын туршлага солилцох зөвлөгөөнөөс энэ оны 7 дугаар сарын 1-нээс 7-ны өдрийг дуустал орон даяар цахилгаан мэдээний 7 хоногийн ажлыг зохион явуулах уриалгыг дэвшүүлэн гаргасан юм.

Энэ уриалгыг биелүүлэхийн тул манай орны хөдөлмөрд, идэр цогтой залуучууд баяртай хүлээн авч

хэрэгжүүлэхээр чармайн ажиллацгааж байна.

Саяхан МХЗ-ийн Төв Хороо, Тээвэр Холбооны Яамнаас орон даяар энэ 7 дугаар сарын 1-7-ныг дуустал цахилгаан мэдээний 7 хоногийг зохион явуулахаар шийдвэрлэв.

1961 оны 7 дугаар сар бол манай нам ба хувьсгалын хийгээд холбооны байгууллагын түүхэнд бичигдэх том үйл явдлаар дүүрэн сар болж өнгөрөх болно.

Цахилгаан мэдээгээр харилцах харилцаа бол социализмын үеийн хүний ухамсар соёл байдла, зан суртахууныг харуулдаг соёл ахуйн нийтлэг чанартай харилцаа юм.

Ийм учраас энэ 7 хоногоор цахилгаан мэдээ бичих аж-

лыг өргөн хэмжээтэй зохиож захидалын 10 хоногт олж авсан туршлагаа улам батжуулах нь чухал шаардагдаж байна.

Цахилгаан мэдээний 7 хоногоор дотоодод явах баярчлал мөндчилгээний энгийн цахилгаан мэдээний үг нэг бүрийн үнийг 50 хувиар хоргдуулж авах юмаа.

Энэ 7 хоногт манай хүн амын соёлжилтын чухал шинж болсон цахилгаан мэдээг авч ээж, ах дүү, төрөл төрөгсөд, анд найз нөхөддөө баяр хүргэж ажлын амжилт хүсэн ерөөсөн цахилгаан мэдээг бичүүлэх ажлыг өргөн зохиож явдал МХЗ Эвлэл, Харилцаа холбооны байгууллагуудын хойшлуулахгүй эрхэм чухал зорилт болж байна. Г. Сэрээтэр

Хөгжлийн их явц

ПРАГ, 6 дугаар сарын 27. (МОНЦАМЭ). Чехословакийн Үндэсний Хурлын өнөөдрийн хуралдаан дээр 1961 оны улсын төсвийн гүйцэтгэлийн тухай депутат Ф. Тимеш илтгэл тавив. Чехословакийн цахилгаан мэдээний агентлаг уламжилсныг үзэв. БНСЧУ 1956-1960 оны хоёрдугаар таван жилийн төлөвлөгөөнд улс ардын аж ахуйг хөгжүүлэх хэрэгт өнгөрсөн жил хамгийн

их амжилт олжээ. Өнгөрсөн жил тус орны үндэсний орлого 8,5 хувь, хөрөнгө оруулалт 11,3 хувь, аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн нийт хэмжээ 11,7 хувь, хувийн хэрэгцээ 9 хувь өсч соёл гэгээрэл, өмнөдөг шийгмийн хэрэгцээнд 40749 сая крон зарцуулсан нь 1956 оныхоос 45 хувиар их юм.

БНСЧУ-ын 1960 оны төсвийн гүйцэтгэлээр орлого нь зарлагаасаа давжээ.

ТҮРЭМГИЙЛЛИЙН ШИНЭ ТӨЛӨВЛӨГӨӨ

НЬЮ-ЙОРК, 6 дугаар сарын 27. (МОНЦАМЭ). БНА ВУ-ын эсрэг хорлон сүйтгэх ажил явуулах төлөвлөгөөний тухай «Чикаго Ньюс» сонин Токиогийн сурвалжлагч Бич уламжилсан байна.

Сурвалжлагчийн үгээр бол тэрхүү төлөвлөгөөг «Америк, Өмнөд Вьетнамын стратегичид» боловсруулж байгаа аж.

«Америкийн цэргийн албан хаагчид, өмнөд вьетнамын армийн цэргийн ангиудтай хамтарч түүнийг гүйцэтгэх юм» гэж сурвалжлагч үзэж байна.

Нго Динь-Дьемын цэргийн байцагчдын үлэмжхэн хувь нь умарт нутгийн хүмүүс болох учир БНАВУ-ын эсрэг явуулах хорлон сүйтгэх төлөвлөгөө нь «цэргийн бодлогын үүднээс үзэхэд туйлын зөв юм» гэж Бич баталжээ.

БНАВУ-ын нутагт нисэх онгоцоор хаях хэсэг тус бүр нь 5-30 хүнтэй байх юм.

«Тэд умарт Вьетнамд хэдэн цаг буюу цаад зах нь хоёр өдөр байж зам, цахилгаан станиц, агуулах зэрэг чухал газруудыг дэлбэлэх буюу хөдөө орон нутгийн захиргаанд ажилладаг коммунистуудыг ч алж болох юм» гэж сурвалжлагч бичжээ.

Бич өгүүлэхдээ, Америкийн нэг үйлдвэрийн эзэн тэр ажиллагаанд дээр эдийн засгийн дайн нэмэлт болгох санал тавьж байна.


БНАВУ-д гаргаж байгаа хувийн үнэмлэх, хүнсний картыг олон саяар нь дууриалсан хийхийг тэрээр санал болгож байна. Түүнээс гадна хуурамч мөнгө хэвлэж БНАВУ-д дэлгэрүүлж болох юм гэж үзэж байна гэж америкийн сурвалжлагч заажээ.

ХАТАН ПОЛИН ЛУМУМБАГИЙН ЯРЬСАН НЬ

БЭЭЖИН, 6 дугаар сарын 28. (МОНЦАМЭ). Патрис Лумумбын бэлбэсэн гэргий хатан Полин Лумумба Стэнливильд синьхуа хорооны сурвалжлагчтай ярилцсан яриандаа мэдэгдэхдээ, империализм Лумумбыг алсан боловч миний нөхрийн амьдралаа зориулсан тэрхүү үйл хэргийг хирэгжүүлэх гэсэн Конгын ард түмний эрс шийдвэрийг тэд мохоож чадахгүй.

«Миний нөхөр амь үрэгдсэн боловч түүний үхэл нь Конгын ард түмэн болон Африкийн бусад орны ард түмэнд сургамж болж империализмууд ба төдний гар хөл болгогчдын эсрэг улам их хүчээр тэмцэхийг уриалсан дохио болж байна» гэж хатан Лумумба сэтгэл хөдлөм ярих.

Хариуцлагатай эрхлэгчийг М. БАЯНХҮҮ



ЗУРАГ ДЭЭР: Бүгд Найрамдах Полн Ард Улсын Тарно бжескийн хүхрийн комбинат.